



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/1790

Булган сум

Цахим тоглоомын газар эрхлэгчдэд
тавих шаардлага, ажиллах цагийн
хуваарь баталж, мөрдүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Булган сумын Хужирт 2 дугаар багийн 109 дүгээр байрны Үйлчилгээний 1-1 тоотод үйл ажиллагаа явуулах хүсэлт ирүүлсэн Б.Өнөмөнх эзэнтэй “Vulgan Z esport” цахим тоглоомын газрын ажиллах цагийн хуваарийг долоо хоногийн Даваа гарагаас Баасан гарагт өглөө 09:00 цагаас орой 22:00 цаг хүртэл, Бямба, Ням гарагт өглөө 10:00 цагаас 22:00 цаг хүртэл, 9-16 насны хүүхдийг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас орой 16:00 цаг хүртэл тоглуулж байхаар баталж, мөрдүүлсүгэй.

2. Цахим тоглоомын газарт Стандарт, хэмжил зүйн хэлтсээс тохирлын гэрчилгээ авч, уг стандарт шаардлагыг хэрэгжүүлж ажиллах, цахим мөрийтэй тоглоом, бооцоот болон тааварт тоглоом тоглуулахгүй байх, цагийн хуваарийг мөрдөн ажиллахыг цахим тоглоомын газрын эзэн (Б.Өнөмөнх)-д даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325011198